

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

НШУС

№ 07/280

2007

МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИЙГ
PR-ИЙН ОЙЛГОЛТООР ТАЙЛБАРЛАХ НЬ

Г.Өнөрбаяр*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.)

Түлхүүр үг: Чингэсийн аян дайн, байлдааны амжилтыг олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөл үзүүлэгч мөнх тэнгэрийн хүч хэмээх домгийн ойлголт, сурталчилгааны үзэл баримтлалтай нь холбон авч үзэв.

Mөнх тэнгэрийн хүчний тухай ойлголт, үзэл номполыг шашин, гүн ухаан, ёс зүй, утга зохиол, нийгэм улс төрийн хүрээнд түгээмэл авч үздэг билээ. Үүний нэгэн адил PR-ийн шинжлэх ухаанд ч гэсэн мөнх тэнгэрийн хүч хэмээх домгийн ойлголтыг авч үзэн тайлбарлах ёстой. Учир нь монгол аймгуудыг нэгтгэх, нэгдсэн эзэнт гүрнийг байгуулах, дэлхийн талыг эзэлсэн дайн байлдаан хийх, нүүдэлчдийн соёл иргэншлийг бий болгох, Чингэс хааныг алдаршуулахад мөнх тэнгэрийн хүч хэмээх ойлголт онцгой нөлөө үзүүлсэн байдаг. Гэвч

мөнх тэнгэрийн хүч хэмээх ойлголт монгол ардын үлгэр, туульсийн ойлголт биш. Харин нийгэм олон нийт, ард түмний санаа бодолд нөлөөлөх, зорилгоор гаргаж ирсэн PR-ийн домгийн ойлголт билээ. Үлгэр туульс, монгол ардын домог нь зохиолын баатрыг алдаршуулах, бусдаас ялгаруулахын тулд адилсуулах, ижилсүүлэх, хүншүүлэх, ер бусын ид шидтэн мэтээр ойлгуулах зорилгоор хийгддэг уран зохиолын дүрслэл юм. Харин PR-ийн домог бол олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх, аливаа ойлголтуудыг өөрчлөх, олон талт харилцааг үүсгэх гэх мэт тодорхой зорилго үндэслэлээр бүтээгддэг хийсвэр ойлголт болно. Тиймээс мөнх тэнгэрийн хүчийг Монгол аймгуудыг нэгтгэх, нэгдсэн улс байгуулах, Чингэсийг алдаршуулах үүднээс зохиогдсон PR-ийн домгийн ойлголт хэмээн авч үзэх үндэстэй юм.

Монгол овог аймгуудыг нэгтгэхийн тулд дайн байлдаан, цэрэг зэвсгийн хүчийг ашиглахаас гадна ард олны санаа бодлыг өөрчлөх, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх PR-ийн шинжтэй олон аргуудыг бий болгон хэрэглэсэний нэг нь мөнх тэнгэрийн хүч хэмээх ойлголт байжээ. Өөрөөр хэлбэл Чингэсийн дайн байлдааны ялалт,

амжилтыг цэрэг зэвсгийн хүч, байлдааны эрдэм, арга тактик, цэргийн зохион байгуулалтаас гадна сурталчилгааны үзэл баримтлалтай нь бас холбон авч үзэх ёстой юм. Ийм байр сууринаас авч үзвэл Чингэсийг мөнх тэнгэрийн

ивээлд багтсан, мөнх тэнгэрийн хүчийг олсон, мөнх тэнгэрийн хүчинд тэтгэгдсэн баатар эр хэмээн олон нийтэд ойлгуулсан нь эрхэмлэн дээдлэх, хүндлэн бишрэх харилцааг бий болгожээ. PR-ийн домгийн ойлголт бол ийм харилцаа, хандлагад оруулах зорилготой байдаг билээ. Тиймээс мөнх тэнгэрийн хүч хэмээх үзэл санаа, сурталчилгааны ойлголтын дор монгол аймгуудыг төдийгүй ази, европын олон улсуудыг нэгтгэсэн эзэнт гүрнийг байгуулах боломж бүрдсэн байдаг.

Мөнх тэнгэрийн хүчийг олж торсон эзэн хааны зарлигийг дагаж мөрдөх нь тэнгэрийн таалалд нийцэж байгаа хэрэг хэмээн сурталчилсан нь түүний удирдлагыг хүлээн зөвшөөрөхөөс өөр замгүй болгож оюун санаа, сонголтынх нь харилцаанд нөлөөлжээ. Тухайн үеийн аян дайны сурталчилгаанд Чингэсийн

«

»

Мөнх тэнгэрийн хүчийг олж торсон эзэн хааны зарлигийг дагаж мөрдөх нь тэнгэрийн таалалд нийцэж байгаа хэрэг хэмээн сурталчилсан нь түүний удирдлагыг хүлээн зөвшөөрөхөөс өөр замгүй болгож оюун санаа, сонголтынх нь харилцаанд нөлөөлжээ. Тухайн үеийн аян дайны сурталчилгаанд Чингэсийн

сүр хүчийг алдаршуулан бусдаас онцгойлон дурддаг байв. Энэ нэг баатарын нэр алдар дор нүүдэлчин овог аймгуудыг сурталчилж байсан хэрэг юм. Орчин үеийн PR ажиллагаанд үүнийг "баатар төрүүлэх" технологи хэмээн нэрлэдэг билээ. Энэ технологийг XIII зуунд мон-

голчууд бий болгон чадварлагаар хэрэглэн өөрсдийн төдийгүй эзэлж авсан улс үндэстнийхээ сэтгэл зүйд нөлөөлсөөр байсныг сурталчилгааны арга барил, тактиктай нь бас холбоотой. Тиймээс байлдан дагуулсан улс бүртээ мөнх тэнгэрийн хүчийг сурталчлан дэлгэрүүлж, мөнх тэнгэрийн хүчинд ивээгдсэн Чингэс хааны суу алдрыг бадруулж "Мөнх тэнгэрийн хүчинд ивээгдсэн их хаан" хэмээх имижийг бүрдүүлж чадсан юм.

"Наран мандахаас шингэх хүртэлх даян дэлхийг мөнх тэнгэрийн хүч

"мөнх тэнгэрийн таалалд эс ивээлдэг", "мөнх тэнгэрийн зарлиг", "мөнх тэнгэрийн са-тэнгэрийн зарлиг", "мөнх тэнгэрийн са-наа", "тэнгэр, газар хүч нэмэн өршөөвөөс", "мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээллээр" гэх мэт уг хэллэг зохимжууд нь эцэстээ мөнх тэнгэрийн хүчиний зарлиг болж олон нийтэд ойлгогдоод зогсохгүй төрийг дээдлэх, хааныг хүндлэх, харилцаанд оруулж нэгдмэл хүчийг бий болгосон. Энэхүү мөнх тэнгэрийн хүчинд итгэж нэгдсэн нэгдмэл хүч, нэг санааны үр дүнд Чингэс хаан алдаршаад зогсохгүй дэлхийн хамгийн том эзэнт гүрнийг байгуулсан. Чингэс хаан "мөнх тэнгэрийн өршөөлөөр, тэнгэр газрын ивээллээр, хүч аугаа нэмэгдэж их улсыг хамтатгаж, ганц жолоондоо оруулсан¹"-аа далдын хүчтэй холбон тайлбарлаж байв. Тэр нь мөнх тэнгэрийн хүч юм. Тиймээс Чингэс хаан өөрийн ялалт амжилт, аян дайны онгodoо мөнх тэнгэрийн хүчтэй холбон тайлбарлаж, ойлгуулж байжээ. Үүний нотолгоо бол Чингэс хаан гурван зуун тайчуудыг дарсны дараа тэнгэр эцэгтээ мөргөж

“Эрэмгиййн сайнаар
Эзэн эс боллоо, би
Эрхэт тэнгэр
Эцгийн хайраар
Эзэн боллоо, би
Эцэг тэнгэрийн ачаар
Эсрэг дайснаа дарлаа, би
Хамрагч сайнаар
Хаан эс болоо, би

Хан тэнгэр эцгийн
Хайраар эзэн боллоо, би
Хан тэнгэр эцгийн өршөөлөөр
Хар дайсныг дарлаа, би² "Хэмээн
исэн үг нь болно. Бас Чингэсийн
дөөс эхлээд өрсөлдөгч дайсан нь
тэл түүнийг мөнх тэнгэрийн хүчийг
он эгэлгүй хүн гэдгийг хүлээн зөв-
эрч алдаршуулж байв. Тухайлбал
мух өөд болохдоо:

“Тэнгэр эцгээс зяатай

Тэмүүжин чамд дийлдэгдэв, би^{эн}
хэмээн өчсөн байдаг. Жамуухын энэхүү
үг, үйл байдал Чингэсийн суу алдрыг
улам өргөж өгсөн билээ.

Мөнх тэнгэрийн хүчний тухай домог нь олон түмэн ардын санаа бодолд нөлөөлж эзэн тэнгэр, эрийн тэнгэр, эхнэрийн тэнгэр, заняаны тэнгэр, баруун, зүүн тэнгэр гэх мэтээр 99 хүртлээ өсөж хуваагдах болсон. Мөнх тэнгэрийн хүчинээс үүдэлтэй тэнгэрийн домог нь үр нөлөөгөөрөө сайн, муу, зүг чигээрээ баруун, зүүн гэх мэтээр олон янзаар салбарлан хөгжик орчин үеийн урлаг утга зохиол, шашин номын сургаальд олон дүрслэлээр илэрхийлэгдсээр байна. Ер нь мөнх тэнгэрийн хүч хэмээх домгийн ойлголт нь эцэстээ номпол сурталчилгааны харилцаа болж хөгжжээ. “Монголын нууч товчоо” болон бусад түүхэн эх сурвалжкуудад Чингэс хаан бол тэнгэрээс гаралтай, ер бусын хүч чадлыг шингээж төрсөн гэсэн өгүүлэмжүүд түгээмэл

байдаг. Энэ нь орчин үеийн ойлголтоор Чингэс хаан бол сайн энергитэй, эрч хүчтэй, хамтын харилцааг чухалчилдаг их хаан гэсэн санааг илэрхийлж байна. Мөн “Монголын нууц товчоо” зохиолд наран, саран, гэрэл гэгээнээс гадна үхрийг тэнгэрийн домогтой холбон авч үзсэн нь бий. Жишээ нь “улаагчин үнээ ирж Жамухыг тойрон явж, Жамухыг ба гэр тэргий нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж, солжир эвэртэй болоод «эврий минь өг» гэж Жамухын зүг мөөрч шороо сацлан байна. Бас нэгэн мухар ухаа үхрийг их тэргэнд хөллөжээ. Тэр үхэр их тэргээр Тэмүүжиний хойноос зүтгэн явж мөөрөн хэлэх нь

«Тэнгэр газар эелдэж (зөвлөж)

Тэмүүжинг улсын эзэн болтугай» гэж Тээж хүргэж явна гэж мөөрнө⁴ хэмээн өгүүлсэнээс үзвэл үхэр тэнгэрийн мэдээч болж байна гэсэн үг юм.

Чингэс хааны язгуурыг дээд тэнгэрээс заяат Бөртэ чоно, Гоомарал хэмээн өгүүлдэг төдийгүй Чингэс хааныг өөд болсныг “Монголын нууц товчоо” зохиолд “тэнгэрт гарав⁵” хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэ нь Чингэсийг төрөхдөө ч, үхэхдээ ч тэнгэртэй холбоотой байсан, тэнгэрийн хүн, тэнгэрт ивээгдэж, тэтгэгдэж ирсэн гэсэн домгийн ойлголтуудыг нь баталгаажуулсан төдийгүй хүний сүнс, оюун ухаан тэнгэрээс ирж буцдаг хэмээх шашин домгийн ойлголтын нэг илэрхийлэл болно. “Монголын нууц товчоо” зохиолд

Чингэс хааныг тэнгэр ивээлдээ багтаадаг төдийгүй Чингэс бол тэнгэрийн санааг хэрэгжүүлдэг гэсэн өгүүлэмжүүд ч түгээмэл гардаг. Үүний нэг жишээ бол Тэмүүжин Тайчуудад хөөгдөж Бурхан халдун ууланд гурав хоноод гарах гэхэд мориноос эмээл нь мултарч унасан, гэрийн чинээ цагаан чулуу замыг бөглөсөн, шугуй ургаж явах газрыг тагласан зэрэг нь домгийн санаа байснаас гадна “тэнгэр ятгаж байгаа”-гаар дүрслэн үзүүлсэн. Мөн “Монголын нууц товчоо” зохиолд Дэв тэнгэр бөөгийн шарил өөрөө алга болсон тухай гардаг. Түүнийг сонссон Чингэс хаан «Дэв тэнгэр, миний дүү нарт гар хөл хүрсэн ба миний дүү нарын хооронд оргүй хов уг хэлсний тул тэнгэрийн таалалд эс нийлж, түүний амь бие хоёуланг тэнгэр авч одов»⁶ хэмээсэн нь домог болно. Ер нь Монголчуудын тэнгэрийг шүтэх философийн үзэл суртал олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч хүчин зүйл болохынхоо хувьд PR-тай холбогддог. Учир нь эрхэм дээдэс, алтан ургийнхныг “тэнгэр язгууртан”, их хаадыг “тэнгэрээс заяагдсан хүмүүс” хэмээн эрхэмлэн дээдлэх, хүнд хэцүү үедээ “дээд тэнгэр”-тээ залбиран сөгдөх, аливаа нэгэн далдын зүйл учир шалтгааныг “тэнгэрийн ятгалга”, үйл ажиллагааны үр дагавар нөлөөллийг “тэнгэрийн таалал”, хууль шүүхийн тогтолцооны мөрдлөг, төр засгийн шийдвэрийн хэрэгжилтийг “мөнх тэнгэрийн хүч” гэж сурталчлах үзэл суртал түгээмэл байснаас

гадна тэгж ойлгон дагах хандлага бүр ч илүү байжээ. Өөрөөр хэлбэл мөнх тэнгэрийн хүчний тухай ойлголт манай ард түмний санаа бодолд төдийгүй аливаа үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйл байсаар ирсэн. Энэхүү нөлөө тэнгэрийг шүтэх үзэл суртал нь Монгол аймгуудын дотоод зөрчлийг зохицуулах, олон нийтийн санаа бодлыг нэгтгэж, цэргийн ардчилалтай төвлөрсөн улс байгуулахад дэвшилтэт үүрэг гүйцэтгэжээ. Мөнх тэнгэрийн хүчний тухай PR ойлголт нь эцэстээ хүч чадалдаа итгэх, эр цэргийн хүчийг шүтэх, монгол аймгуудыг нэгтгэж, нэгдсэн хүчтэй болох, монгол баатруудын санаа бодлыг дайн тулааны өмнө бэлтгэх, Чингэсийг тэнгэрээс заяагдсан хүмүүн хэмээн шүтүүлж, цэргийн эрдмийнх нь дор их үйл хэргийг бүтээх, өрсөлдөгч хийгээд дайснуудын хүч зоригийг мөхөөхөд онцгой нөлөөлсөн гэж үзэх үндэстэй. Тиймээс мөнх тэнгэрийн хүчний үр дүнд Монгол аймгууд нэгдэж, дэлхийн талыг эзэлж, Чингэсийг хожим “мянганы хүмүүн” хэмээн хүлээн зөвшөөрүүлж, XIII зууныг Монголын зуун гэж хэлүүлэхэд хүргэжээ. Энэхүү мөнх хөх тэнгэрийн хүчний тухай PR-ийн ойлголт “тэнгэрийн үнэлэмж” өнөө ч манай ард түмний санаа бодолд онцгой байр суурь эзэлж байна. Үүнийг Д.Бямбасүрэнгийн хязгааргүй уудам мөнх тэнгэр анхдагч⁷ гэсэн ойлголтоос гадна П.Очирбатын жам ёсны зүйлийг “Тэнгэрийн цаг”⁸ хэмээн тодотгосноос харж болно. Бас

монголчууд одоо ч өөрсдийгөө тэнгэрийн хүмүүс гэсэн домогоо хөх толбоороо нотлон үзүүлдэг билээ. Мөн төрийн тамганд “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын далай хааны зарлиг ил булха иргэн дор хүрвээс биширтугэй, аюутгай” гэсэн байдаг. Уг тамганы уг нь мөнх тэнгэрийн хүч, далай хаан, иргэн гэсэн гурван харилцаа холбоог илэрхийлсэнээс гадна төр ард түмний шүтэлцээг маш товчоор харуулсан билээ. Мөн хасбуу тамгыг хүртэл мөнх тэнгэрийн хүчинд шившигдсэн учир хасбуу тамгатай төрийн хууль цааз, хааны зарлиг шийдвэрийг гүйцэтгэх, бишрэх, дагах ёстой гэж олон нийтэд ойлгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл төрийн хасбуу тамганд мөнх тэнгэрийн хүчийг тариндан шившсэн гэсэн домгийн ойлголт ч тухайн үеийн олон нийтийн санаа бодолд онцгой нөлөө үзүүлсээр байжээ. Тиймээс монголчууд өөрсдийн амьдралын дэвжин дээшлэх, гандан буурахыг хүртэл мөнх тэнгэрийн хүчтэй холбон тайлбарлаж ирэв.

Mөнх тэнгэрийн хүч бол хүний гарал үүсэл, нэр алдрыг дуурсгах, хорвоогийн сайн сайхан, ер бусын эрч энергээр төсөөлж тайлбарлах, тэгж итгүүлэх замаар эзэн хааны суу алдрыг өргөх имижийг бүрдүүлэх арга нь болжээ. Их Монгол Улсыг байгуулах, эзэн Чингэсийг алдаршуулах, олон овог аймаг үндэстний санаа бодлыг өөрчлөхөд онцгой нөлөө үзүүлсэн мөнх

тэнгэрийн хүч хэмээх ойлголт өнөөдөр ч гэсэн Монголчуудын сэтгэл зүйд үлдсэн нь домгийн зохиомжийг сайн гаргасан, олон зуунаар итгэн үнэмшсэн зэрэгтэй холбоотойгоос гадна эрхэм дээд, тэнгэрийн гэсэн имиж нь үүнийг өнөө хүртэл хадгалан үлдэхэд нөлөөлжээ. Тиймээс мөнх тэнгэрийн хүч хэмээх ойлголт нь олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөгчийнхөө хувьд PR-ийн домгийн ойлголт болно. Ийм байр суурин аас авч үзвэл 1900 оны үеэс эхлэн шинжлэх ухаан болж хөгжсөн PR-ийн арга технологиудыг монголчууд XIII зууны үед чадварлагаар хэрэглэж байжээ хэмээн дүгнэж болох юм.

Ишлэл

¹ 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ. 195 дахь тал.

² 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ. 104 дэхь тал.

³ 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ. 175 дахь тал.

⁴ 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ. 73 дахь тал.

⁵ 2006. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн Ш.Чоймаа. УБ. Соёомбо принтинг. 220 дахь тал.

⁶ 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ. 215-216 дахь тал.

⁷ Бямбасүрэн Д. 1995. Орчлонгийн хүрд. УБ.

⁸ Очирбат П. 1996. Тэнгэрийн цаг. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
2. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
3. 1990. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Дамдинсүрэн Ц. УБ.
4. 2006. Монголын нууц товчоо. Хөрвүүлсэн: Чоймаа Ш. УБ.
5. 2006. Мөнх тэнгэр судлал. Редактор: Гэрэлбаатар Г. УБ.
6. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. /Тэргүүн боты/
7. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. УБ. /Тэргүүн дэвтэр/
8. Өнөрбаяр Г. 2004. Улс төрийн PR. УБ.
9. Өнөрбаяр Г. 2007. Олон нийтийн санаа бодол & PR.

Resume

This article stipulates power of eternal blue sky as a notion of a legend of PR. It discusses that power of eternal blue sky is a factor that affects mindset and wisdom of human being. With specific evidence and documentary examples it also proves that such a power served as a main concept for glorifying Chingis Khaan.